



2022.04.19

Дундбүрд

「 ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗАРТ

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.8 дахь хэсэгт “Орон нутгийн хурлын ээлжит бус, нөхөн, дахин сонгуулиар нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь төрийн аудитын дээд байгууллагаас тогтоосон хугацаанд сонгуулийн мөрийн хөтөлбөр болон энэ хуулийн 25.3.6, 25.4.6-д заасан хандивын тайландаа дүгнэлт гаргуулахаар төрийн аудитын байгууллагын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ” заалтын дагуу 2020 оны орон нутгийн сонгуулийн мөрийн хөтөлбөр, байгууллагын харилцах *593600.996.8*..... тоот дансны тайлант жилийн хуулга хүргүүлж байна. Нөхөн сонгуультай холбогдуулан хандивын данс шинээр нээгээгүй бөгөөд дээрх дансанд хандив ороогүй нь үнэн болно.

ДАРГА



Б.ЖАВХЛАНБАЯР



2022.04.19

Дугаар 02.....

Дундбүрд

Г ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 7

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн 2021 оны нөхөн сонгуульд Хэнтий аймгийн Батноров сумын Ардын намын хорооны 2020 оны мөрийн хөтөлбөр оролцоно. Тус мөрийн хөтөлбөрийн эдийн засгийн тооцоолол, баримт бичигт өөрчлөлт ороогүй болно.

ДАРГА  Б.ЖАВХЛАНБАЯР



2020.06.22

Дундбүрд

БАТНОРОВ СУМЫН МАН-ЫН 2020-2024 ОНЫ ИТХ-ЫН СОНГУУЛИЙН  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Анд нөхөрлөлийн өлгий нутаг Батноров Сумынхаа иргэд хөдөлмөрчид, малчин түмний эрүүл мэнд, боловсролд онцгойлон анхаарч, иргэдийн өрхийн орлогыг нэмэгдүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхэд энэхүү мөрийн хөтөлбөрийн зорилго оршино.

1. БОЛОВСРОЛ, СОЁЛ, БИЕИЙН ТАМИР СПОРТЫН САЛБАРТ

1.1 Сумын ЕБС-ийн өргөтгөлийг ажиллагаанд оруулж, хуучин сургуулийн анги танхимын ширээ сандал, гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчилж хэрэгцээ хангамжийг нэмэгдүүлнэ.

1.2 Сургууль, цэцэрлэгийг стандарт шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжтай болгоно.

1.3 Олон Улс, Улс аймгийн олимпиадад амжилттай оролцож байр эзэлсэн болон, өөрийн заадаг хичээлээрээ элсэлтийн ерөнхий шалгалтанд сурагчдыг амжилттай бэлтгэж аймаг Улсад тэргүүлсэн багш нарт урамшуулал олгоно.

1.4 Сумын сургуулийн өмнөх насны хүүхдийн тоон үзүүлэлт, анги танхимын хүрэлцээ хангамж нь одоогийн байдлаар хоцрогдолтой байгаатай холбогдуулан 200 хүүхдийн цэцэрлэг шинээр барина.

1.5 Хүүхэд багачуудад зориулсан тоглоомын талбайг Жавхлант эгнээний урд талд, Бүрдийн гэр хорооллын урд тус тус шинээр байгуулна.

1.6 Сурагчдын харилцааны соёл, хүмүүжил, төлөвшлийг сайжруулахад анхаарч, Сумын сургуульд сэтгэл зүйч шинээр ажиллуулах ба нийгмийн ажилтны үүрэг хариуцлагыг нэмэгдүүлнэ.

1.7 Сумын төвд нийтийн халуун усны газарыг шинээр байгуулна.

1.8 Бүрд хэсэгт нийтийн биеийн тамирын талбайг шинээр барьж байгуулна.

1.9 Барамсай зааны нэрэмжит спорт заалыг ашиглаж, үндэсний бөх болон бусад бөхийн төрлүүд, волейбол, агаарын тэннис, бадминтон, сагсан бөмбөгийн секц дугуйланг ажиллуулж Улс аймаг, орон нутгийн уралдаан тэмцээнд тамирчдыг Төр, аж ахуй нэгж байгууллага, иргэдийн дэмжлэг, ивээн тэтгэлэгээр оролцуулж хүүхэд залуучуудын бие бялдарыг хөгжүүлж, тамирчдын залуу халааг бэлтгэнэ.

1.10 Номын сангийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.

1.11 Орон нутгийн судлах танхимын үйл ажиллагааг идэвхижүүлж, баяжилтыг тогтмол хийж ажиллана.

1.12 Өрх бүр "УГИЙН БИЧИГ" аяныг өрнүүлж, иргэд малчдын дунд уралдаан зарлаж, дүгнэн тэднийг урамшуулж ажиллана.



1.13 Хөлөг баатар Боорчийн “АНДГАЙ” дуулалт жүжгийг Батноров Сумын түүхт 100 жилийн ойг угтаж баримтат кино болгож ажиллана.

1.14 Боловсролын салбарыг улс төрөөс ангид байлгаж, сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийг мэдлэг, чадвар, ажлын гүйцэтгэл, туршлагад нь үндэслэн сонгон шалгаруулж томилно.

1.15 “ҮДИЙН ХООЛ” хөтөлбөрийг үргэлжлүүлж, хүүхдэд шим тэжээл, амин дэмээр баялаг хоолоор үйлчилнэ.

1.16 “Насан туршийн боловсрол” хөтөлбөрийн хүрээнд насан туршдаа суралцах боломжийг бүрдүүлнэ.

1.17 ЕБС-ийн орчинд хүүхдийн тооноос хамааран мэргэжлийн эмч ажиллах бололцоог бүрдүүлж ажиллана.

## 2. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР

2.1 Түүхэн аялал жуулчлалын бодлогод нийцүүлэн Андлалын өргөөний барилга угсралт, тохижилтын ажлыг гүйцээж, цаашид тогтвортой ажиллах нөхцөлийг бий болгоно.

2.2 Жуулчдын орон нутагт таатай аялаж зугаалах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор нийтийн ариун цэврийн байгууламж бүхий буудал, үйлчилгээний байгууллагыг бий болгоход онцгойлон анхаарч санхүүгийн болон зуучлалын үйлчилгээг үзүүлнэ.

2.3 Суманд үйл ажиллагаа явуулж буй буудал, нийтийн хоолны ажиллагсадыг чадвахижуулах сургалтанд хамруулж, үйлчилгээний соёл, чанар, ая тухтай байдлыг нэмэгдүүлнэ.

2.4 Аялагчдад зориулсан орон нутгийн онцлогтой, үнэ цэнэтэй бэлэг дурсгалын болон хэрэглээний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг үйлдвэрлэлийг дэмжиж бий болгоно.

2.5 Жил бүр зохион байгуулагддаг “Талын түмэн адуу” “Тайга нохой”-ны Эвент арга хэмжээг тогтмолжуулж, түүнийг тойрсон ажил үйлчилгээний соёл, төрлийг нэмэгдүүлнэ.

2.6 “БАТНОРОВЫН БРЭНД” дэд хөтөлбөрийг үргэлжлүүлж, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэн шошгожуулна.

## 3. ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР

3.1 Сумын эрүүл мэндийн төвийн өргөтгөлийг барьж, иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

3.2 Сумын эмнэлэгийн тоног төхөөрөмжийн хэрэгцээ шаардлагад нийцсэн тоног төхөөрөмжөөр хангах бодлого явуулж, ЭХО-той болгоно.

3.3 Сумын эрүүл мэндийн төвд шүдний эмчилгээний үйлчилгээг бий болгож улмаар мэргэжлийн эмч ажиллуулна.

3.4 Сумын эрүүл мэндийн төвийг стандарт шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжтай болгох бөгөөд дотроо халуун ус, душтэй болгоно.



Handwritten signature and red circular stamp of the Batnоров Sum Citizens' Khural.

Handwritten text in red ink on the right margin.

23171-  
0A0046

3.5 Нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээг тогтолцоогоор нь: тавигдаж буй шаардлагад нийцүүлж, үр дүнд хүргэж, аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх дадал хэвшилд ард иргэдийг сургана.

3.6 Хавдраас урьдчилан сэргийлэх үзлэг үйлчилгээг тогтмолжуулсанаар иргэдийг бүрэн хамруулж эрт илрүүлэлтийг сайжруулаж, хавдраар нас баралтыг бууруулна.

3.7 “ЭЛЭГ БҮТЭН МОНГОЛ” “ЭРҮҮЛ ШҮД-ЭРҮҮЛ ХҮҮХЭД” хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлж, түүнтэй уялдсан дэд хөтөлбөрүүдийг боловсруулсанаар “ХАВДРЫН ЭСРЭГ ХАМТДАА” хөтөлбөрийг орон нутагтаа хэрэгжүүлнэ. Урьдчилан сэргийлэх вакцинд хамрагдалтыг нэмэгдүүлж, элэгний хорт хавдрын эсрэг дархлааг бий болгоно.

3.8 Хүн амын ундны усны аюулгүй байдлыг хангах үүднээс нийтэд үйлчилж буй худгийн усыг шинжилгээнд хамруулж, хүн амын унданд хэрэглэх стандартад нийцсэн эсэхэд хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллана.

3.9 Иргэн бүрийг эрүүл мэндийн оношилгоонд жил бүр хамруулна.

#### 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ ЧИГЛЭЛЭЭР

4.1 Өнгөт чулуу олборлолтыг таслан зогсоож, өнгөт чулуу олборлосон газруудад нөхөн сэргээлт хийнэ.

4.2 Малчдын бүлгийн нөхөрлөл, АРАВТ хэсгүүдийн иргэдийн оролцоог нэмэгдүүлж, төсөл хөтөлбөр, байгаль хамгаалах сантай хамтарч жил бүр нэгээс доошгүй бүлгийг хашиж хамгаална.

4.2 Уул уурхайд эвдэрсэн газрын судалгаа гаргаж, эзэн холбогдогчтойг эзэн холбогдогчоор нь, эзэнгүйг нь төсөл хөтөлбөртэй хамтарч нөхөн сэргээх арга хэмжээ авна.

4.3 Тарвага нутагшуулах, тарвага ховордсон газар нутгийг малчдад хариуцуулан гэрээлж иргэдийн оролцоотой хамгаалалтыг бий болгоно. Өөрөөр хэлбэл хөдөөгийн малчид бүхэн идэвхитэн байгаль хамгаалагч байх нөхцөл бололцоог бүрдүүлэн ажиллана.

4.4 Сумын ногоон байгууламжийн эзлэх хувийг нэмэгдүүлж, нутгийн удирдлагын ордон, цэцэрлэгт хүрээлэн, төв зам дагуу 1000 аас доошгүй бут сөөг мод тарьж арчлан ургуулна.

4.5 Сумын нэгдсэн хогийн цэгийг улирал тутам түрэх, дарах зэргээр цэгцэлж хог тарах, хийсэхгүй байх тал дээр анхаарч, орчныг бохирдуулахгүй байх нөхцөлийг хангана.

4.6 Малчдын хуурай хог хаягдлаа Сумын нэгдсэн хогийн цэгт хүргэдэг болгож нутаг усныхаа газрын гадарга хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4.7 Жилд 2 удаа усны сан бүхий газрууддаа нийтийн их цэвэрлэгээг хийж, шаардлагатай усны сан бүхий газруудыг тэмдэгжүүлнэ.



Handwritten red text and a stamp on the right margin. The stamp contains the numbers "297" and "074082".

4.8 Шингэн хог хаягдлын цэгийг тогтоож, төв цэвэрлэх байгууламжийг байгуулж, Сумын төвийн хаус тохилог сууцыг сулладаг буюу стандарт шаардлага нийцсэн ариун цэврийн байгууламжтай болгоно.

4.9 Малчдын ОО-ыг байгальд ээлтэй хөрс бохирдуулахгүй байх шийдэл шаардлагыг хангасан ОО-той болгоно.

## 5. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ЧИГЛЭЛЭЭР

5.1 Улаан өндөр хайрханыг буруутай этгээдээр нөхөн сэргээлгэж орон нутгийн хамгаалалтанд авна.

5.2 Салхитын цагаан толгойн олборлолтыг зогсоож нөхөн сэргээнэ.

5.3 Нөхөрлөлийг орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах, өрхийн орлого нэмэгдүүлэхэд чиглүүлж ажиллуулна.

5.4 Нөхөрлөлийн үйл ажиллагааг зөвшөөрөгдсөн хууль эрх зүйн хүрээнд уулын ажлын төлөвлөгөөний дагуу ажиллаж байгаа тал дээр хяналт тавьж, нөхөн сэргээлтийг төлөвлөгдсөн хэмжээнд чанартай хийлгэж хүлээн авна.

5.5 Уул уурхай үйл ажиллагаанд тавих орон нутгийн хяналтыг сайжруулж, орон нутагтай хамтран ажиллах нийгмийн хариуцлагын гэрээг ил тод байгуулж, гүйцэтгэл тайланг иргэдэд мэдээлж ажиллана.

5.6 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй томоохон үйлдвэр аж ахуй нэгж байгууллагуудад орон нутгийн иргэдийг түлхүү ажиллуулах бодлого барина.

5.7 Шинээр ажил үйлчилгээ явуулах гэж байгаа болон ажлын байр нэмэгдүүлэх төсөл хөтөлбөрүүдийг дэмжиж хөнгөлттэй зээл олгох, бүтээгдэхүүн борлуулалтыг дэмжих зэргээр боломжтой бүх дэмжлэг үзүүлнэ.

5.8 Малжуулах бодлогыг Төр олон нийтийн оролцоотой явуулж, шинээр малчин болж буй малчид болон цөөн малтай иргэдийг малжуулах төсөл хөтөлбөрт хамруулан ажиллана.

5.9 Малчдын аравтын системийг төгөлдөржүүлж, бэлчээр ашиглалт, худаг ус гаргах, ноос, ноолуур, угаалга зэрэг цаг үеийн ажлыг хамтын хүчээр зохион байгуулах хамтач үзэл санааг төлөвшүүлэх.

5.10 Туслах малчдын нийгмийн хамгаалал, хариуцлагыг албажуулахад онцгойлон анхаарч, хөдөлмөрийн болон түрээсийн гэрээг албан ёсоор хийж баталгаажуулдаг тогтолцоог бий болгоно.

5.11 Малын эрүүл мэнд, үүлдэр, чанар, товарлиг байдлыг сайжруулахад орон нутаг бий болсон мал эмнэлэгийн үржлийн салбарт бодлого оролцоог тодорхой болгож, малчдад үзүүлэх мал эмнэлийн ажил үйлчилгээний төрөл болон чанарыг сайжруулна.

5.12 Үхсэн малын сэг, зэмийг дарж булшлах, халдварт өвчнөөр хорогдсон малын сэг зэмийг дарж устгах, ариутгал халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг багийн засаг даргын хяналт доор чанартай хийж гүйцэтгэнэ.



5.13 Сумын ИТХ-аар малчдын хамтын сангийн дүрмийг боловсруулан оруулж баталгаажуулан, дундын сангаар мал угаалгын ванн, өвс тэжээлийн аюулгүйн фонд, худаг уст цэг гаргах зэргээр мал аж ахуйн өмнө тулгамдсан асуудлыг малчдаас санал авч эрэмбэлэн хэрэгжүүлнэ.

5.14 Баг, Сумын түвшинд тухайн жилийн ургамал, ногооны гарц, зуншлага, өвөлжилтийн төлөв байдалтай уялдуулан, малчид баг, сумын хэмжээнд үүсч болох маргаан зөрчлөөс сэргийлэх зорилгоор бэлчээрийн төлөвлөлтийг хийж мөрдөн ажиллана.

5.15 Суманд мал нядалгааны орчин үеийн шаардлага хангасан цахилгаан хөргүүр бүхий мал нядалгааны нэгдсэн цэгийг байгуулж, мал махыг гадаад, дотоод зах зээлд зардал, чирэгдэл багатай борлуулах боломж нөхцлийг бүрдүүлнэ. Малчдын өрхийн орлогыг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлнэ.

5.16 Үлийн цагаан оготонотой байгаль эколгит халгүй аргаар тэмцэж , бэлчээрийн доройтол болон цөлжилтийн эсрэг хийх ажлыг идэвхижүүлнэ.

5.17 Төмс хүнсний ногоог тариалалтыг нэмэгдүүлж, орон нутгийн хэрэгцээг бүрэн хангаж, хураан авсан төмс хүнсний ногоог жилийн турш стандарт шаардлагад нийцсэн, хадгалах нөхцлийг хангасан зоорьтой болоход санаачлага гарган, иргэн аж ахуй нэгжийг дэмжиж, жилийн турш төмс хүнсний ногоогоо хадгалан хэрэглэх нөхцлийг хангана.

5.18 Нарийн ногоо тарих иргэд болон аж ахуй нэгжүүдийг хүлэмжээр хангах бодлого барьж, хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийг 50-аас доошгүй %-аар нэмэгдүүлнэ.

5.19 Малын эрүүл мэндийн удмын сангийн хуулийн хэрэгжилтийг хангаж, вакцинжуулалт, угаалга, туулгалт болон цаг үеийн ажилд ажиллах хүчийг дайчлан гаргаж, малчдад чанартай үйлчилгээг үзүүлнэ.

5.20 Гарааны бизнес эрхлэгч оюутан , залууст бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

5.21 “МОНГОЛ МАЛ”-2 хөтөлбөрийг суманд хэрэгжүүлж , чанар ашиг шимийг сайжруулах ажлыг эрчимжүүлж, малын тоог чанарт шилжүүлж, ашиг шим, хүртээмжийг сайжруулах, малын генийн санг хамгаална.

5.22 Мал эмнэлэгүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах ба тэдний үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

## 6. НИЙГМИЙН ХАЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР

6.1 Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд тулгуурлан хүнсний талон зэрэг нийгмийн халамжийн үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэгт чиглүүлнэ.

6.2 Орлого багатай өрхийн нийгмийн хамгаалал, амьжиргааг дээшлүүлэх олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг нэвтрүүлнэ.

6.3 Залуу гэр бүлийн эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүй, хөгжлийн хэрэгцээг дэмжсэн “ЗАЛУУ ГЭР БҮЛ” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.



6.4 Ахмад настны чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрүүлэх, хөгжих боломжийг бүрдүүлэх , ахмадын байрыг тохижуулна.

6.5 Ахмад настны орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээх ажил эрхлэлт, зөвлөх үйлчилгээг үр дүнтэй хэлбэрээр үргэлжлүүлнэ.

#### 7. ИРГЭН ТӨВТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ТӨГӨЛДӨРЖҮҮЛНЭ.

7.1 Батноров сумын төвд нутгийн удирдлагын ордонг шинээр барьж ашиглалтанд оруулна.

7.2 Уурын зуухны хүчин чадалд тулгуурлан айл өрхүүдийн хувийн орон сууцуудыг нэгдсэн халаалтад холбох бодлого баримтлана.

#### 8. БЭРХ 7-Р БАГТ ХИЙГДЭХ АЖИЛ

8.1 1980 оноосхойш шинэчлэгдээгүй Бэрх хотын 23,5 км инженерийн шугам сүлжээний иж бүрэн шинэчлэлийн ажлыг бүрэн хийж дуусгана.

8.2 Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төвийн үйл ажиллагааг өргөжүүлж бүтээн байгуулалт болон, шинээр байгуулагдах үйлчилгээний салбараар дамжуулан иргэдийн байнгын орлоготой болгож ажлын байраар хангана.

8.3 Иргэдийн ая тухтай ажиллаж амьдрах таатай орчин бүрдүүлэх, гэмт хэрэг зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Орон сууц болон гэр хорооллын гэрэлтүүлгийг иж бүрэн шинэчилж камержуулна.

8.4 Гэр хорооллын айл өрхийн усан хангамжийг шийдвэрлэх зорилгоор тус хотын баруун жаран гэрийн дунд ухаалаг түгээлттэй инженерийн хийцтэй гүний худаг барина.

8.5 Бэрх хотод олон улсын хөтөлбөртэй чанарын шаардлага хангасан жишиг сургуулийг барьж дуусгана.

Мөрийн хөтөлбөр  
баталсан МАН-ын дарга



Б.Ган-Эрдэнэ





## УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР

### ХИЙГДЭХ АЖЛУУД

1. 200 хүүхдийн цэцэрлэг шинээр барих ----- 2.500.0
2. ЭМТ-ийн өргөтгөл барих ажил ----- 400.0
3. Хуучин ЕБС-ийн парк шинэчлэл -----100.0
4. ЕБС-ийн өргөтгөлийг шинээр барих-----150.0
5. Нутгийн удирдлагын ордонг шинээр барих-----2.500.0
6. Монголын далд уурхайн музей 3.200.0
7. Бэрх хотод олон улсын хөтөлбөртэй чанарын 4.900.0  
шаардлага хангасан жишиг сургуулийг барих.

### ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР

1. Нийтийн халуун ус -----150.0
2. Булгуудын эхийг хашиж хамгаалах -----30.0
3. Тоглоомын талбайг шинээр барих -----500.0
4. Иргэдийн ая тухтай орчин / Бэрх / 150.0
5. Гэр хорооллын айл өрхийн усан 42.0  
хангамжийг шийдвэрлэх

